

*2018 оны 12 дугаар сард шинэчлэн батлав.*

## Clubhouse Хөтөлбөр Олон Улсын Стандарт

Clubhouse Хөтөлбөрийн Олон Улсын Стандарт нь дэлхийн бүх ClubHouse-уудын зөвшилцөлийн үндсэн дээр батлагдаж нөхөн сэргээлтийн ClubHouse загварыг тодорхойлдог.

Олон улсын стандартад орсон зарчмууд нь сэтгэцийн өвчтэй хүмүүс нийгмийн, санхүүгийн, боловсролын ба хөдөлмөр эрхлэлтийн зорилгогоо хүрэхэд нь үр дүнтэйгээр туслах тухай чиглүүлэлт юм. Энэхүү баримт бичигт орсон стандартууд нь сэтгэцийн өвчтэй гишүүдийнхээ хувьд тэдний эрхийг хамгаалах хууль, албан хаагч, захирал, ТУЗ-ын гишүүдийн ба бусад % удирдах ажилтнуудын хувьд бол ёс зүйн хэм хэмжээ нь болж өгдөг. Стандартууд нь ClubHouse загварыг гишүүддээ хүндлэлтэй харилцан ажиллаж тэднийг боломжоор хангаж байх үндсэн агуулгаасаа хазайхгүй байхад тууштай чиглүүлж байх ёстой.

Олон улсын итгэмжлэл олгохдоо эдгээр стандартуудад үндэслэж тухайн ClubHouse-д чанарын үнэлгээ хийдэг.

Дэлхийн ClubHouse-уудын нийгэмлэгүүд 2 жил тутамд стандартууддаа үнэлгээ дүгнэлт хийж шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулдаг. Энэхүү үнэлгээ дүгнэлт хийх үйл явцыг Олон улсын ClubHouse Стандартын үнэлгээний хорооноос зохион байгуулдаг ба уг Хороо нь дулхийн итгэмжлэгдсэн ClubHouse-уудын гишүүд ба албан хаагчдын төлөөллүүдээс бүрддэг.

### **Гишүүнчлэ**

1. гишүүнчлэл нь сайн дурын ба хугацаагүй.

2. Clubhouse шинэ гишүүдээ хүлээн зөвшөөрөх тал дээр хяналт тавдаг ба ингэхдээ ямар нэгэн байдлаар сэтгэцийн өвчний түүхтэй хэнийг ч гэсэн хүлээн авах боловч ClubHouse хамт олонд мөн өөртөө ямар нэгэн хор хөнөөл үзүүлэхгүй байхад анхаардаг.

3. ClubHouse загвараас хэрхэн үр өгөөж хүртэх ба хамт олон дундаас хэнтэй хамтарч ойр ажиллаха гишүүн өөрөө сонгодог ба гишүүдийн оролцонд ямар нэгэн хатуу тогтсон гэрээ, дүрэм, цагийн хуваариар бататгахгүй.

4. гишүүд аль ч Clubhouse-д онош болоод үйлдэл гүйцэтгэх чадварын ялгаагүйгээр тэгш хамрагдан оролцох боломжтой.

5. Гишүүдийн хийсэн сонголт тэдний тэмдэглэлд бичгээр үйлдэгдэж байх ба ClubHouse-н албан хаагч болон тухайн гишүүний хэн хэн нь гарын үсгээр баталгаажуулсан байна.

6. удаан хугацаагаар оролцоогүй байсан ч гэсэн ямар нэг хүндрэлгүйгээр шууд эргэн гишүүн болох эрхтэй ба гагцхүү тухайн гишүүний эргэн ирсэн төлөв байдал нь Clubhouse хамт олондолонд ямар нэг хор хөнөөл учруулахааргүй байхад анхаардаг.

7. ирэхгүй байгаа юмуу орчноосоо тусгаарлагдаа байгаа юмуу эмнэлэгт хэвтэх шаардлагатай болсон гишүүддээ зориулан 'хүрч очих' систем ажиллуулдаг.

## **Харилцаа**

8. Clubhouse-ын бүх хурал албан хаагч ба гишүүдэд тэгш байдлаар нээлттэй явагддаг ба зөвхөн гишүүдэд хамааралтай асуудлуудыг хэлэлцдэг гишүүдийн хурал ч юмуу эсвэл хөтөлбрийн шийдвэр гаргах түвшний зөвхөн албан хаагчдын хурал гэж байдаггүй.

9. Clubhouse албан хаагчдын тоо хэмжээ гишүүнчлэл авах боломжийг хангаж өгөхүйц байдаг. Цалинтай албан хаагчдын тоо гишүүдийг ажилгүйдүүлэхгүйгээр байх хэрэгтэй.

10. Clubhouse албан хаагчид Ерөнхий ажил үүргийн хуваарьтай ажилладаг. Бүх албан хаагчид хөдөлмөр эрхлэлт, орон сууц, нийгэмшүүлэлтийн үйл ажиллагаануудад нэгэн жигд оролцдог. Clubhouse албан хаагчид нь албан хаагч-

гишүүн харилцааны уугуул онцлог шинжээ хадгалж ажиллахын тулд үндсэн ажил ба сайн дурын ажил гэж ялгах ёсгүй.

11. Clubhouse үйл ажиллагаатай холбоотой хариуцлага гишүүд ба албан хаагчдад хамааралтай ба нэн шаардлагатай тохиолдолд ClubHouse Захирлыг оролцуулдаг. ClubHouse-н үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлаархи хариуцлагын төвд нь албан хаагчид ба гишүүд байх юм.

12. Clubhouse нь өөрийн гэсэн тодорхой нэр, шуудангийн хаяг, утасны дугаар зэрэгтэй байна.

13. Clubhouse өөрийн байранд ажиллах ба ямар нэг институт юмуу бусад төрлийн эрүүл мэндийн төвүүдээс тусдаа өөр хөтөлбөрүүдэд уусалгүйгээр ажилладаг. “Ажлын захиалгат өдөр” хөтөлбөрөө сонирхолтойгоор, хүчин чадал сайтагаар хүндэтгэлтэйгээр явуулахад чиглүүлэлтээр сайн хангаж өгдөг байх нь чухал.

14. зөвхөн гишүүдийн ажиллах хэсэг эсвэл зөвхөн албан хаагчдын ажиллах хэсэг гэж байхгүй.

### **Ажлын захиалгат өдөр**

15. ClubHouse-ыг ажиллуулахдаа албан хаагчид ба гишүүд нэгэн адил эрх үүрэгтэйгээр хамтрагчид хэлбэрээр ажилладаг. зүрхэн тольт болсон “ажлын захиалгат өдөр” нь гишүүдийхээ давуу тал, авьяас, чадварт суурилжявдаг учраас ямар нэг эмийн эмчилгээ, засал, сувилахуйн үйлчилгээнүүд хийгддэггүй.

16. Clubhouse дотор хийж буй бүхий л үйл ажиллагаа зөвхөн түүнээс өөрөөс нь үүсэлтэй бас өөрт нь чиглэгдсэн байх ёстой. Албан хаагчид ба гишүүд аль алиных нь гадуур эрхлэж буй сайн дурын ч бай цалинтай ч бай ямар нэг ажил ClubHouse-д хамааралгүй ба түүний хүрээнд хийхийг хүлээн зөвшөөрөхгүй. Гишүүд ямар нэг цалин урамшуулал авахгүй ба хиймлээр урамшууллын систем гэж зохиох ёсгүй.

17.долоо хоногт дор хаяж таван өдөр ажлын хуваарь цагийн дагуу ажиллана.

18. Clubhouse нь нэг болон түүнээс дээш тооны нэгжүүдэд хуваагддаг ба ажлын нэгж бүр дор бүрнээ албан хаагч ба гишүүдээс бүрдсэн байна. нэгж бүрийн хийх ажил, хүний тоо нь тэнцвэртэй байх хэрэгтэй. ажлын нэгж бүр дор бүрнээ хуралдаж нэг нэгнээ мэдээллээр хангах харилцаа холбоо сайтаагаар ажиллах боломжийг олгохоос гадна тухайн өдрийнхөө ажлын хуваарийг гаргадаг.

19. ClubHouse-д хийгдэж буй бүх ажил гишүүдийг өөрийнхөө үнэ цэнийг мэдэрсэн зорилготой өөртөө итгэлтэй болоход нь урамшуулж дэмжих зорилго агуулах ба ямар нэгэн мэргэжлийн ур чадвар олгоход чиглэхгүй юм.

20. гишүүд бүхий л ажилд оролцох боломжтой. үүнд удирдлага, захиргаа, судалгаа, элсүүлэлт, танилцуулга, хүрч очих, ажилд авах, сургалт ба албан хаагчид үнэлгээ хийх, олон нийттэй харилцах, нөлөөлөл хийх, ClubHouse үйл ажиллагаанд үнэлгээ хийх зэрэг орно.

### **Хөдөлмөр эрхлэлт**

21.гишүүдээ шилжилтийн, дэмжлэгтэйгээр, бие даасан гэсэн аргачлалуудаарцалинтай ажилд ороход нь дэмжиж тэусалдаг. Тиймээс тусгаарласан асрамжийн байрны хэлбэрээр ажил хийлгэх юмуу дотроо ажлын байр гаргаж өгөхийг хориглоно.

### **Шилжилтийн хөдөлмөр эрхлэлт**

22. Clubhouse өөрийн шилжилтийн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөртэй. Хөдөлмөрийн зах зээл дээр ажлын байранд зуучлуулж ажиллах боломжийг олгож байгаа юм.- ClubHouse-ийн өөрийнх нь шилжилтийн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр учраас тухайн гишүүнийхээ ажилдаа очиж чадаагүй цагуудад нөхөн төлбөр олгодог. Мөн дараахи шаардлагуудыг хөнгөж ажилладаг:

а. ажилд зуучлахдаа зөвхөн чин хүсэл эрмэлзэлтэй байхыг л шаарддаг

б. Өмнөх зуучилж оруулсан ажилд хэр амжилттай байснаас үл хамааран дахин ажилд зуучлуулах боломж хэвээр үлдэнэ

в. Гишүүдийн ажил тухайн ажил олгогчийн ажлын байранд байрлана

г. ажилд орсон гишүүд тухайн ажлын байранд төлөгддөг тогтсон цалинтг нээгн адил авна. Хамгийн доод талдаа амьдралын хамгийн бага түвшигөөс доогуур бус цалин авах ёстой. Цалингаа шууд ажил олгогчоос авна.

д. Шилжилтийн хөдөлмөр эрхлэтүүд нь сонголт өргөнтэй байна

е. Шилжилтийн хөдөлмөр эхлэлт нь хагас цагийн ажил байх ба долоо хоногт 15-20 цаг ажилладаг байх ба 6-9 сар үргэлжилнэ.

ё. Шилжилтийн хөдөлмөр эрхлэлтэнд зуучлуулах гишүүнээ сонгох ба шаардлагатай сургалтанд хамруулж бэлтгэх нь ClubHouse-ын үүрэг хариуцлага байна

ж. гишүүний хөдөлмөр эрхлэлтэнд тусалж дэмжсэн бүхий л талуудад эргэн тайлангнах нь ClubHouse албан хаагч ба гишүүний үүрэг байна

з. Шилжилтийн хөдөлмөр эрхлэлтийг ClubHouse албан хаагч ба гишүүд өөрсдөө зохион байгуулдаг ба тусгай мэргэжилтэн ажилладаггүй

и. ClubHouse дотроо шилжилтийн ажлын байр үүсгэхгүй ба тусламжийн байгууллага дотроо бас үүсгэхгүй. Дээрхи шаардлагуудын алт нэгийг зөрчихгүйгээр шилжилтийн хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулан.

### **Дэмжлэгтэй ба бие даасан Хөдөлмөр Эрхлэлт**

23. Clubhouse өөрийн дэмжлэгтэй хөдөлмөр эхлэлтийн хөтөлбөрөөрөө дамжуулж гишүүдээ ажилдаа удаан тогтоход нь, албан тушаалаа ахиулах нь тухайн гишүүн болон ажил олгогч нарын хооронд харилцаа үүсгэн Clubhouse-ын албан хаагчийн зүгээс тухайн ажлыг эрхэлж буй гишүүнд ямар төрлийн дэмжлэг тусалцаа ямар давтамжтайгаар үзүүлэх хэрэгтэй байгааг тодорхойлон тусалдаг.

24. бие даасан хөдөлмөр эрхлэлтэнд хамрагдан ажиллаж буй гишүүн ClubHouse-ын зүгээс үзүүлдэг боломж үйлчилгээнд үргэлжлүүлэн хамрандаж болох ба оройн ба амралтын өдрүүдийн нийгэмжүүлэх үйл ажиллагаанд чөлөөтэй оролцдог байна

### **Боловсрол**

25. нийгэмд байгаа үйлчилгээнүүдээс бусдын адил үр өгөөжийг нь хүртэн хөдөлмөр эхлэлт болон боловсролын зорилготоо хүрэхэд нь тусалдаг. өөрийн боловсролын хөтөлбөрөө ClubHouse баран дээрээ явуулдаг ба гишүүдийнхээ өөрсдийнх нь нөөц бололцоог ашиглан заах, чиглүүлэн зөвлөх үйлчилгээ явуулдаг.

## **Ажиллагаа**

26. Clubhouse байршил нь нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломжтой байх ба шилжилтийн ажил хийж буй байгууллага руугаа ч бас зорчих боломжтой байх ёстой. Нийтийн тээвэр хомс нөхцөлд унаа тээврийн асуудлыг ямар нэгэн байдлаар зохицуулж өгнө.

27. олон нийтийн дэмжих үйлчилгээ үзүүлэхэд албан хаагчид ба гишүүд өөрсдөө явуулна. ингэхдээ ажлын нэгжүүдийнхээ хөтөлбөрүүдэд хамруулан оруулсан байна. олон нийтийн дэмжих үйлчилгээнүүд: эрх бүхий үйлчилгээнүүдэд хамрагдах, орон сууцны хөтөлбөрт хамрагдах, нөлөөлөл хийх, эрүүл амьдралын хэв маягт дадах, эрүүл мэндийн, эмийн эмчилгээний, сэтгэл зүйн, мансууруулах бодисын нөлөөнд хэт авталтаас хөндийрөх зэрэг үйлчилгээнүүдийг чанартайгаар авахад нь туслах зэрэг орно.

28. гишүүдээ эрүүл амьдралын хэв маягаа тогтоож өөртөө тохирсон загвараа гаргахад нь туслах зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

29. гишүүдийнээ бие даасан амьдралыг дэмжин дундаж тохилог, төлбөрийг нь дийлэхүйц орон сууцны сонголтоор хангахад хүчин чармайлт гарган ажиллана. Тийнүү орон сууцны боломжоор хангах боломжгүй бол өөрийн орон сууцны хөтөлбөрөө ажиллуулна. ClubHouse орон сууцны хөтөлбөр нь дараахи шаардлагуудыг хангсан байна:

- а. уг хөтөлбөрийг албан хаагч ба гишүүн хамтдаа зохион байгуулж ажиллуулна
- б. Орон сууцны хөтөлбөрт хамрагдан амьдрах гишүүд өөрийн сонголтоор шийднэ
- в. Амьдрах сууцныхаа байршил ба хажуу өрөөнд суух хүнээ өөрөө сонгоно
- г. Орон сууцны хөтөлбөрийн бодлого журмыг ClubHouse-ын үндсэн соёлтой нийцүүлэн боловсруулсан байна

д. Гишүүнд үзүүлэх дэмжлэг туслалцаа нь тухайн гишүүний хэрэгцээ шаардалгад гарч буй өөрчлөлтийг даган багасч эсвэл нэмэгдэж болно

е. Албан хаагчид ба гишүүд эмнэлэгт хэвтэж буй гишүүнийхээ орон сууцыг хадгалж үлдэхийн тулд идэвхитэй харилцаатай байж анхаарал тавьдаг.

30. өөрийн үйл ажиллагааны үр дүнд тодорхой хугацаанд үнэлгээ хийдэг ба эдгээр үнэлгээний нэг нь Clubhouse Олон Улсын Итгэмжлэл байна.

31. Clubhouse захирал, албан хаагч, гишүүн хийгээд шаардлагатай хүмүүс ClubHouse загвараар боловсруулсан 2-3 долоо хоногийн цогц сургалтанд итгэмжлэгдсэн сургалтын төвүүдийнх нь аль нэгэнд сургалтанд хамрагдан.

32. Clubhouse нь орон цагаар ба амралтын өдрүүдээр нийгэмжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Албан ёсны тэмдэглэлт өдрүүдийг тогтсон өдрүүдэдэ нэгэн адил тэмдэглэнэ.

### **Санхүүжилт, Удихдлага, Захиргаа**

33. Clubhouse биеэ даасан Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байх юмуу эсвэл аль нэг санхүүжүүлэгч талынхаа төлөөлөн удирдах зөвлөлд хамрагдаж болно. Тусдаа төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн ClubHouse-дсанхүүгийн, хуулийн, хөдөлмөр эрхлэлтийн нийгмийн, болон нөлөөллийн талаас зөвлөгөө дэмжлэг үзүүлэх хүмүүсээс бүрдсэн байна.

34. Clubhouse нь өөрийн төсвийг төлөвлөж зузаатгаж ажиллана. Өөрийн бие даасан төлөөлөлн удирдах зөвлөлөөрөө юмуу санхүүжүүлэгч талынхаа төлөөлөн удирдах зөвлөлөөр хувь нэмэртэйгээр тухайн санхүүгийн жилийн эхнээс батлуулж жилийн үйл ажиллагаагаа тудний хяналт зөвлөгөөн дор явуулна.

35. албан хаагчдын цалин сэтгэцийн эрүүл мэндийн салбарын дүйцэхүйц ажлын байрны цалинтай тэнцэхүйц байна.

36. Clubhouse нь сэтгэцийн эрүүл мэндийн салбарын эрх бүхий хүмүүсийн дэмжлэгийг хүлээсэн байх ба бусад шаардлагатай зөвшөөрлүүдийг авсан байна. үйл ажиллагаанд үр дүнтэй нөлөө үзүүлэхүйц хүмүүс ба байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулж явахыг хичээнэ.

37. Clubhouse нь нээлттэй форум хийдэг ба үүгээрээ албан хаагчид ба гишүүддээ ClubHouse-ын удирдлага, бодлого, ирээдүйн хөгжил, чиглэлтэй холбоотой асуудлуудаар ерөнхий зөвшилцөлд хүрэх замааршийдвэр гаргах боломжийг өгдөг.

Clubhouse International, 747 Third Avenue – 2nd Floor New York, New York 10017 USA  
October 1989

© Revised as of December 2018 Telephone: 212 582 0343 Web: [www.clubhouse-intl.org](http://www.clubhouse-intl.org)